



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Сэлэнгэ сумын Эрүүл мэндийн төвийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аудитын код: БУА-2022/76/НА-СТА-ТШЗ

<p>Цахим хуудас: www.audit.mn</p> <p>Булган хот 2022 он</p>	<p>Дарга, тэргүүлэх аудитор: Д.Анхбаяр Утас: 70342580 Цахим хаяг: Anhbayrd@audit.gov.mn</p> <p>Аудитын менежер: Ж.Энхцоодол Утас: 70342716 Цахим хаяг: Enhtsoodol@audit.gov.mn</p> <p>Аудитор: А.Сувдаа Утас: 70342495 Цахим хаяг: Suvdaaa@audit.gov.mn</p>
-------------------------------------------------------------------------------------------------------	-----------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Агуулга

2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл	5
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан	5
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан	6
2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан	8
2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	9
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан	10
2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан.....	12
3. Аудитын тайлан.....	13
3.1 Ерөнхий зүйл.....	13
3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт	13
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал	13
3.4 Материаллаг байдал	14
3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга	14
3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв.....	15
3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг.....	16
3.8 Аудитын гол асуудал	16
3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	16
3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт	16
3.10 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт.....	17
3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал.....	17
4. Аудитын илрүүлэлт	18
4.1 Залруулсан алдаа	18
4.2 Албан шаардлага	18
4.3 Зөвлөмж.....	20
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл	0

Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
НА	Нийцлийн аудит
НБББББ	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг
НДШ	Нийгмийн даатгалын шимтгэл
НӨАТ	Нэмэгдсэн өртгийн албан татварын тайлан
СТА	Санхүүгийн тайлангийн аудит
ТШЗ	Төсвийн шууд захирагч
УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт



**БУЛГАН АЙМГИЙН
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

Анхдагчдын өргөн чөлөө 1-120,
Жаргалант баг, Булган сум, Булган аймаг, 63082
Утас/Факс: 7034-3259
E-mail: bulgan@audit.gov.mn

2022.02.25 № 99

танай _____ ны № _____ т

СЭЛЭНГЭ СУМЫН ЭРҮҮЛ
МЭНДИЙН ТӨВИЙН ДАРГА
Ө.БҮЖИНЛХАМ ТАНАА

Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Сэлэнгэ сумын Эрүүл мэндийн төвийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Дүгнэлтийн үндэслэл хэсэгт дурдсан алдаа, зөрчлийн үр нөлөөг эс тооцвол Сэлэнгэ сумын Эрүүл мэндийн төвийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний байгууллагаас цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Тайлант онд тооллогыг бүрэн явуулаагүй, харилцагч байгууллага, иргэнтэй 93.1 мянган төгрөгийн тооцоо нийлж баталгаажуулаагүй, батлагдсан орон тооноос нэг орон тоо хэтрүүлэн баталж үргүй зардал гаргасан, 2020 оны санхүүгийн тайлан сөрөг дүгнэлттэй, зөвлөмжийг бүрэн хэрэгжүүлээгүй зэрэг зөрчлүүд нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйл 16.5.3, 16.5.4, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйл 20.2.4, 20.2.5-д заасныг тус тус хэрэгжүүлж ажиллаагүй, эрх үүрэг, үнэн зөв болон тохиолдсон байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

D:/bichighereg/2022A4toot

006020170

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.


Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Д.АНХБАЯР

2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон

/төгрөгөөр/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	<u>32,637,952.28</u>	<u>264,071,412.37</u>
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	-	7,997,896.00
312	Банкинд байгаа бэлэн мөнгө	-	7,997,896.00
3121	Төгрөг	-	7,997,896.00
31211	Төрийн сангийн харилцах	-	7,997,896.00
33	АВЛАГА	275,935.88	121,670,400.00
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	275,935.88	-
33300	Татаас, санхүүжилтийн авлага	-	120,400,400.00
335	Бусад авлага	-	1,270,000.00
3351	Байгууллагаас авах авлага	-	1,270,000.00
35	БАРАА МАТЕРИАЛ	32,362,016.40	134,403,116.37
351	Түүхий эд материал	12,280,042.40	88,383,922.20
35110	Тусгай зориулалттай материал	3,934,000.00	2,115,000.00
35130	Эм боох материал	8,346,042.40	86,268,922.20
354	Хангамжийн материал	19,659,974.00	45,557,194.17
35410	Бичиг хэргийн материал	-	100,000.00
35420	Аж ахуйн материал	12,735,146.00	22,192,447.00
35440	Түлш, шатах тослох материал	2,760,000.00	10,490,000.00
35450	Барилгын засварын материал	-	3,636,021.00
35460	Хүнсний материал	2,974,928.00	6,645,355.00
35470	Бусад хангамжийн материал	1,189,900.00	2,493,371.17
35600	Мал амьтад	422,000.00	462,000.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	<u>446,435,293.06</u>	<u>458,381,196.60</u>
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	446,435,293.06	458,381,196.60
392	Биет хөрөнгө	426,767,293.06	437,430,696.60
39201	Барилга, байгууламж, орон сууц	339,908,237.36	339,908,237.36
39202	Хуримтлагдсан элэгдэл	(38,826,981.04)	(48,292,801.30)
39203	Авто-тээврийн хэрэгсэл	105,237,898.00	86,937,898.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	(44,119,281.46)	(31,743,233.56)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	85,255,199.23	119,777,674.79
39206	Хуримтлагдсан элэгдэл	(29,668,130.96)	(37,049,290.29)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	18,418,730.28	18,418,730.28
39208	Хуримтлагдсан элэгдэл	(9,438,378.35)	(10,526,518.68)
393	Биет бус хөрөнгө	19,668,000.00	20,950,500.00
39301	Програм хангамж	-	1,350,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-	(67,500.00)
39303	Бусад биет бус хөрөнгө	19,668,000.00	19,668,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	<u>479,073,245.34</u>	<u>722,452,608.97</u>
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	-	<u>1,735,619.00</u>
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	-	1,735,619.00
413	Өглөг	-	1,735,619.00
41310	Ажилчидтай холбогдсон өглөг	-	909,619.00
41320	Бараа үйлчилгээний зардлын өглөг	-	412,400.00
4136	Бусад өглөг	-	413,600.00
41361	Байгууллагад төлөх өглөг	-	413,600.00
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	<u>479,073,245.34</u>	<u>720,716,989.97</u>
51	Засгийн газрын хувь оролцоо	479,073,245.34	720,716,989.97
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	279,647,290.31	279,647,290.31
512	Хуримтлагдсан үр дүн	(34,674,826.94)	206,968,917.69

Сэлэнгэ сумын Эрүүл мэндийн төвийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

51210	Өмнөх үеийн үр дүн	(34,674,826.94)	(34,674,826.94)
51220	Тайлант үеийн үр дүн	-	241,643,744.63
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	234,100,781.97	234,100,781.97
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	<u>479,073,245.34</u>	<u>722,452,608.97</u>

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	527,018,936.89	1,059,033,994.23
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	77,155,476.89	273,818,326.23
120	Нийтлэг татварын бус орлого	77,155,476.89	273,818,326.23
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	11,519,051.50	272,000.00
1E+06	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	11,519,051.50	272,000.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	449,863,460.00	785,215,668.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	372,904,800.00	437,391,300.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	372,904,800.00	437,391,300.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	14,909,700.00	176,537,038.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	14,231,000.00	174,559,838.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	678,700.00	1,977,200.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	27,908,700.00	28,350,000.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	27,713,000.00	28,350,000.00
132006	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /аймгаас авсан санхүүгийн дэмжлэг/	195,700.00	-
1340	Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих	34,140,260.00	142,937,330.00
134002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	34,140,260.00	142,937,330.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	493,863,055.66	817,118,249.60
21	УРСГАЛ ЗАРДАЛ	493,863,055.66	817,118,249.60
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	492,033,277.66	779,482,485.60
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	292,534,562.00	335,716,224.00
210101	Үндсэн цалин	190,628,768.00	197,333,372.00
210102	Нэмэгдэл	83,282,432.00	92,668,829.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	-	5,046,000.00
210104	Урамшуулал	18,623,362.00	40,668,023.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	39,255,764.12	45,393,663.88
210201	Тэтгэврийн даатгал	27,542,564.12	31,951,534.88
210202	Тэтгэмжийн даатгал	2,928,300.00	3,382,953.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,342,600.00	2,674,998.00
210204	Ажилгүйдлийн даатгал	544,085.00	703,907.00
210205	Эрүүл мэндийн даатгал	5,898,215.00	6,680,271.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	24,576,386.00	17,956,836.00
210301	Гэрэл, цахилгаан	3,882,900.00	5,380,836.00

Сэлэнгэ сумын Эрүүл мэндийн төвийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

210302	Түлш, халаалт	19,973,486.00	12,278,500.00
210303	Цэвэр, бохир ус	720,000.00	297,500.00
2104	Хангамж, бараа материалын зардал	17,544,964.00	19,412,883.00
210401	Бичиг хэрэг	1,480,000.00	2,252,059.00
210402	Тээвэр, шатахуун	10,957,820.00	12,952,575.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,536,800.00	1,215,200.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	1,609,644.00	2,260,899.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	834,700.00	655,150.00
210407	Аж ахуйн материал худалдан авах зардал	-	77,000.00
210408	Бараа материал акталсны зардал	1,126,000.00	-
2105	Нормативт зардал	50,947,735.95	305,528,414.70
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	43,829,928.35	290,100,391.70
210502	Хоол, хүнс	7,107,807.60	15,428,023.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	10,000.00	-
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	3,760,000.00	7,768,979.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	140,000.00	-
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	803,500.00	1,819,000.00
210604	Урсгал засвар	2,816,500.00	5,949,979.00
2107	Томилолт, зочны зардал	937,700.00	940,000.00
210702	Дотоод албан томилолт	937,700.00	940,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	20,628,542.00	18,839,285.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	19,746,542.00	18,335,000.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	882,000.00	-
210803	Даатгалын үйлчилгээ	-	300,000.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	-	83,250.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	-	70,000.00
210807	Газрын төлбөр	-	40,500.00
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	-	10,535.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	41,847,623.59	27,926,200.02
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	3,820,000.00	3,999,628.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	38,027,623.59	23,926,572.02
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	1,829,778.00	37,635,764.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	1,472,000.00	36,120,000.00
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	-	24,000,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	1,472,000.00	12,120,000.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	14.00	-
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	14.00	-
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	357,764.00	1,515,764.00
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	357,764.00	1,515,764.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	<u>33,155,881.23</u>	<u>241,915,744.63</u>
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	312,472.23	272,000.00
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	14,472.23	-
225005	Үнэ төлбөргүй гарсан зардал	298,000.00	272,000.00
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	(312,472.23)	(272,000.00)
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	<u>32,843,409.00</u>	<u>241,643,744.63</u>

2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон						/төгрөгөөр/
Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Бусад	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
C01	2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	-	-	-	-	-
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	-	-	-
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	-	-	-	-	-
C04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт	-	-	-	-	-
C05	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт	-	-	-	-	-
C06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	-	-	-	-	-
C07	Тайлант үеийн үр дүн	-	-	-	-	-
C08	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	-	-	-	-	-
D01	2021 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	279,647,290.31	234,100,781.97	(34,674,826.94)	-	479,073,245.34
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	-	-	-
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	-	-	-	-	-
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	-	-	-	-	-
D05	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт	-	-	-	-	-
D06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	-	-	-	-	-
D07	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	-	-	-	-	-
D08	Тайлант үеийн үр дүн	-	-	241,643,744.63	-	241,643,744.63
D09	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	279,647,290.31	234,100,781.97	206,968,917.69	-	720,716,989.97

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон		/төгрөгөөр/	
Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	449,863,460.00	664,815,268.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	449,863,460.00	664,815,268.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	372,904,800.00	437,391,300.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	372,904,800.00	437,391,300.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	14,909,700.00	176,537,038.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	14,231,000.00	174,559,838.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	678,700.00	1,977,200.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	27,908,700.00	28,350,000.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	27,713,000.00	28,350,000.00
132006	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /аймгаас авсан санхүүгийн дэмжлэг/	195,700.00	-
1340	Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих	34,140,260.00	22,536,930.00
134002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	34,140,260.00	22,536,930.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	447,417,960.00	644,566,372.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	447,417,960.00	644,566,372.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	445,860,182.00	606,930,608.00
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	292,534,562.00	334,806,605.00
210101	Үндсэн цалин	189,162,500.00	196,423,753.00
210102	Нэмэгдэл	84,748,700.00	92,668,829.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	-	5,046,000.00
210104	Урамшуулал	18,623,362.00	40,668,023.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	39,531,700.00	45,117,728.00
210201	Тэтгэврийн даатгал	27,818,500.00	31,675,599.00
210202	Тэтгэмжийн даатгал	2,928,300.00	3,382,953.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,342,600.00	2,674,998.00
210204	Ажилгүйдлийн даатгал	585,700.00	703,907.00
210205	Эрүүл мэндийн даатгал	5,856,600.00	6,680,271.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	24,896,486.00	24,284,236.00
210301	Гэрэл, цахилгаан	3,882,900.00	5,380,836.00
210302	Түлш, халаалт	20,293,586.00	18,605,900.00
210303	Цэвэр, бохир ус	720,000.00	297,500.00
2104	Хангамж, бараа материалын зардал	18,970,120.00	25,926,584.00
210401	Бичиг хэрэг	1,480,000.00	2,169,859.00
210402	Тээвэр, шатахуун	10,967,320.00	15,580,175.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,536,800.00	1,215,200.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	2,622,400.00	2,570,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	2,363,600.00	4,391,350.00
2105	Нормативт зардал	40,474,372.00	143,199,342.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	31,690,164.00	120,221,792.00
210502	Хоол, хүнс	6,570,808.00	19,055,550.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	2,213,400.00	3,922,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	3,566,700.00	9,216,500.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	750,200.00	-
210604	Урсгал засвар	2,816,500.00	9,216,500.00
2107	Томилот, зочны зардал	937,700.00	940,000.00
210702	Дотоод албан томилот	937,700.00	940,000.00

Сэлэнгэ сумын Эрүүл мэндийн төвийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	20,628,542.00	18,839,285.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	19,746,542.00	18,335,000.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	882,000.00	-
210803	Даатгалын үйлчилгээ	-	300,000.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	-	83,250.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	-	70,000.00
210807	Газрын төлбөр	-	40,500.00
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	-	10,535.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	4,320,000.00	4,600,328.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	4,320,000.00	4,600,328.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	1,557,778.00	37,635,764.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	1,200,000.00	36,120,000.00
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	-	24,000,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	1,200,000.00	12,120,000.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	14.00	-
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	14.00	-
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	357,764.00	1,515,764.00
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	357,764.00	1,515,764.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	<u>2,445,500.00</u>	<u>20,248,896.00</u>
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	2,249,800.00	12,251,000.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	2,249,800.00	12,251,000.00
2200	Дотоод эх үүсвэрээр	2,249,800.00	12,251,000.00
222001	Тоног төхөөрөмж	1,949,800.00	12,251,000.00
223001	Бусад хөрөнгө	300,000.00	-
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	<u>(2,249,800.00)</u>	<u>(12,251,000.00)</u>
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	195,700.00	7,997,896.00
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		-
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	7,997,896.00

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	503723300.00	478764570.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	503723300.00	478764570.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	502723300.00	477844570.00
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	326167800.00	316473795.00
210101	Үндсэн цалин	202216500.00	196423753.00
210102	Нэмэгдэл	93637300.00	92668829.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	6048000.00	5046000.00

Сэлэнгэ сумын Эрүүл мэндийн төвийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

210104	Урамшуулал	24266000.00	22335213.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	44032500.00	42139178.00
210201	Тэтгэврийн даатгал	30985900.00	29628309.00
210202	Тэтгэмжийн даатгал	3261700.00	3150013.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	2609300.00	2525026.00
210204	Ажилгүйдлийн даатгал	652300.00	621439.00
210205	Эрүүл мэндийн даатгал	6523300.00	6214391.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	25800000.00	24284236.00
210301	Гэрэл, цахилгаан	3185000.00	5380836.00
210302	Түлш, халаалт	22315000.00	18605900.00
210303	Цэвэр, бохир ус	300000.00	297500.00
2104	Хангамж, бараа материалын зардал	21731700.00	21367979.00
210401	Бичиг хэрэг	1780000.00	1776859.00
210402	Тээвэр, шатахуун	14342400.00	14339570.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,486,800.00	1,215,200.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	2,622,500.00	2,570,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,500,000.00	1,466,350.00
2105	Нормативт зардал	43,750,000.00	43,244,269.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	30,800,000.00	30,797,269.00
210502	Хоол, хүнс	8,940,000.00	8,525,000.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	4,010,000.00	3,922,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	6,200,000.00	6,101,000.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	5,000,000.00	4,901,000.00
210604	Урсгал засвар	1,200,000.00	1,200,000.00
2107	Томилолт, зочны зардал	1,900,000.00	280,000.00
210702	Дотоод албан томилолт	1,900,000.00	280,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	21,933,900.00	20,189,285.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	19,281,900.00	18,335,000.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	432,000.00	-
210803	Даатгалын үйлчилгээ	300,000.00	300,000.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	409,500.00	83,250.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	70,000.00	70,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	1,350,000.00	1,350,000.00
210807	Газрын төлбөр	40,500.00	40,500.00
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	50,000.00	10,535.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	11,207,400.00	3,764,828.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	11,207,400.00	3,764,828.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	1,000,000.00	920,000.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	1,000,000.00	920,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	1,000,000.00	920,000.00
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	65,695,000.00	486,762,466.00
1310	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	-	437,391,300.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	-	437,391,300.00
1320	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	27,713,000.00	26,834,236.00
132001	Орон нутгийн төсвөөс	27,713,000.00	26,834,236.00
1340	НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	37,982,000.00	22,536,930.00
134002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	37,982,000.00	22,536,930.00
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		

Сэлэнгэ сумын Эрүүл мэндийн төвийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		7,997,896.00
6	ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ		
61	БАЙГУУЛЛАГЫН ТОО	1.00	1.00
610001	Төсвийн байгууллага	1.00	1.00
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	24.00	24.00
620001	Удирдах ажилтан	1.00	1.00
620002	Гүйцэтгэх ажилтан	18.00	18.00
620003	Үйлчлэх ажилтан	5.00	5.00

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Гүйцэтгэл
I	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	176,537,038.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	176,537,038.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	141,337,038.00
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	18,332,810.00
210104	Урамшуулал	18,332,810.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	2,978,550.00
210201	Тэтгэврийн даатгал	2,047,290.00
210202	Тэтгэмжийн даатгал	232,940.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	149,972.00
210204	Ажилгүйдлийн даатгал	82,468.00
210205	Эрүүл мэндийн даатгал	465,880.00
2104	Хангамж, бараа материалын зардал	4,558,605.00
210401	Бичиг хэрэг	393,000.00
210402	Тээвэр, шатахуун	1,240,605.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	2,925,000.00
2105	Нормативт зардал	99,955,073.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	89,424,523.00
210502	Хоол, хүнс	10,530,550.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	14,016,500.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	6,000,000.00
210604	Урсгал засвар	8,016,500.00
2107	Томилолт, зочны зардал	660,000.00
210702	Дотоод албан томилолт	660,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	835,500.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	835,500.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	35,200,000.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	35,200,000.00
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	24,000,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	11,200,000.00
II	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	176,537,038.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	176,537,038.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	174,559,838.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	1,977,200.00

3. Аудитын тайлан

3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Сэлэнгэ сумын Эрүүл мэндийн төвийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Энэхүү тайланд шалгагдагч байгууллагад анхан шатны баримт бүрдүүлэлтийг сайжруулахтай холбоотой өгсөн зөвлөмжийг тусгасан болно.

Аудитыг 2022 оны 2 дугаар сарын 12-оос 2022 оны 2 дугаар сарын 25-ны хооронд Булган аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор А.Сувдаа гүйцэтгэж, хяналтыг чанарын хяналтыг аудитын менежер Ж.Энхцоодол, дарга, тэргүүлэх аудитор Д.Анхбаяр хэрэгжүүлсэн.

Сэлэнгэ сумын Эрүүл мэндийн төвийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Булган аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 1 дүгээр сарын 24-ний өдрийн 08 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Байгууллагын зорилго нь Байгууллагын бүтэц зохион байгуулалтыг боловсронгуй болгон, эрүүл мэндийн тусламж үйлчилгээг стандарт технологийн дагуу үзүүлж тусламж үйлчилгээний чанар аюулгүй байдлыг сайжруулах, нийгмийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээг сайжруулж иргэдийг өвчлөлөөс урьдчилан сэргийлэх, мэдлэг хандлагыг нэмэгдүүлэхэд оршино.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрдөх хууль, тогтоомж, бодлого чиглэлд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

- ЗГ-ын 2021 оны 43 дугаар тогтоол “Төсвийн хэмнэлтийн талаар авах арга хэмжээний тухай”
- ЗГ-ын 2021 оны 124 дүгээр тогтоол “Босго үнэ шинэчлэн батлах тухай”;
- Сангийн сайдын 2021 оны 190 дугаар тушаалаар “Зардлын эдийн засгийн ангилал ашиглах заавар”

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлагналдаа мөрдөх Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг аймгийн Засаг даргын А/424 тоот захирамжаар 2020 онд батлуулж Төсвийн тухай хууль болон УСНББОУС-д нийцүүлэн Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан “Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар, санхүүгийн тайлан тодруулгын маягт, санхүүгийн тайлан бэлтгэж гаргах аргачлал”-ыг тусгасан байна.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр

санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Сэлэнгэ сумын Эрүүл мэндийн төвийн 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Мөн төсвийн гүйцэтгэлийн тайланг Төсвийн тухай хуулийн 54.5-д заасны дагуу бүрэлдэхүүн хэсгээр иж бүрэн бэлтгэж ирүүлээгүй байна.

3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2020 оны нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл дунд гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 1.5 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2020 оны нийт зардлын 494,175.5 мянган төгрөгөөс 1.5 хувиар буюу 7,412.6 мянган төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлаар тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

Сэлэнгэ сумын Эрүүл мэндийн төвийн 2021 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 243,379.4 мянган төгрөгөөр буюу 50.8 хувиар өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан харилцах, авлага, эм боох материал, аж ахуйн материал, түлш шатах тослох материал, машин тоног төхөөрөмж, хуримтлагдсан элэгдэл, хуримтлагдсан үр дүнгийн данснууд байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	/мянган төгрөг/		
	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	0.0	7997.9	7997.9
Урьдчилж гарсан тооцоо	275.9	121670.4	121394.5
Бараа материал	32362.0	134403.1	102041.1
Үндсэн хөрөнгө	446435.3	458381.2	11945.9
Нийт хөрөнгө	479073.2	722452.6	243379.4
Өр төлбөр	0.0	1735.6	1735.6
Хуримтлагдсан үр дүн	479073.2	720717.0	241643.7
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	479073.2	722452.6	243379.4

Дансны үлдэгдэл гарсан материаллаг дүнтэй дараах өөрчлөлтүүд байна. Үүнд:

- Тайлант онд 7,997.9 мянган төгрөгийн үлдэгдэлтэй,
- ЭМДХ-ээс санхүүжилт дутуугаас 120,400.4 мянган төгрөгөөр өссөн,
- Эм боох материал ковид-19 цар тахал гарсантай холбоотойгоор 77,922.9 мянган төгрөгөөр өссөн;
- Аж ахуйн материал 9,457.3 мянган төгрөг, түлш шатах тослох материал 7,730.0 мянган төгрөгөөр нэмэгдсэн,
- Машин тоног төхөөрөмж 34,522.5 мянган төгрөгөөр нэмэгдсэн;
- Тайлант үеийн үр дүн 241,643.7 мянган төгрөгөөр нэмэгдсэн;
- Үндсэн хөрөнгө данс тайлант оны элэгдлийн зардлаас голлон шалтгаалж 40,141.8 мянган төгрөгөөр буурсан;

Хүснэгт 2. Санхүүгийн үр дүнгийн тайлангийн үзүүлэлт /мянган төгрөг/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он	Өөрчлөлт	Хувь
1	Үйл ажиллагааны орлого	527,018.94	1,059,033.99	532,015.06	100.9%
11	Татварын орлого	-	-	-	
12	Татварын бус орлого	77,155.48	273,818.33	196,662.85	254.9%
120004	Төсөвт байгууллагын үйл ажиллагаанаас	11,519.05	272.00	(11,247.05)	-97.6%
122	Тусламжийн эх үүсвэрээс санхүүжих	-	-	-	
13	Тусламж, санхүүжилтийн орлого	449,863.46	785,215.67	335,352.21	74.5%
1310	Улсын төсвөөс санхүүжих	372,904.80	437,391.30	64,486.50	17.3%
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	14,909.70	176,537.04	161,627.34	1084.0%
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	27,908.70	28,350.00	441.30	1.6%
1330	Төсвийн захирагчаас	-	-	-	
1340	НДС-аас санхүүжих	34,140.26	142,937.33	108,797.07	318.7%
14	Бусад эх үүсвэр			-	
2	Үйл ажиллагааны зардлын дүн	493,863.06	817,118.25	323,255.19	65.5%
21	Урсгал зардал	493,863.06	817,118.25	323,255.19	65.5%
210	Бараа, ажил үйлчилгээний зардал	492,033.28	779,482.49	287,449.21	58.4%
211	Хүү	-	-	-	
212	Татаас	-	-	-	
213	Урсгал шилжүүлэг	1,829.78	37,635.76	35,805.99	1956.8%
22	Хөрөнгийн зардал	-	-	-	
3	Үйл ажиллагааны үр дүн /3=1-2/	33,155.88	241,915.74	208,759.86	629.6%
145	Үйл ажиллагааны бус орлого	-	-	-	
225	Үйл ажиллагааны бус зардал	312.47	272.00	(40.47)	-13.0%
4	Үйл ажиллагааны бус үр дүн /4=145-225/	(312.47)	(272.00)	40.47	-13.0%
5	Нийт үр дүн /5=3+4/	32,843.41	241,643.74	208,800.34	635.7%

Сэлэнгэ сумын Эрүүл мэндийн төвийн санхүүгийн үр дүнгийн тайлангийн нэмэлт санхүүжилтийн орлого өмнөх оноос 161,627.3 мянган төгрөг буюу 10.8 дахин өссөн, нийт орлого 532,015.1 мянган төгрөгөөр буюу 1.0 дахин, үйл ажиллагааны зардал 323,255.2 мянган төгрөгөөр буюу 0.7 дахин өсөж, төлөвлөсөн санхүүжилтийг зарцуулж ажилласан байна.

3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.6.1 Төсвийн төлөвлөлт

Сангийн яамнаас урсгал зардлыг 503,723.3 мянган төгрөгөөр баталсан байна.

3.6.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 4 арга хэмжээг санхүүжүүлэхээр 437,391.3 мянган төгрөгийг улсын төсвөөс, 27,713.0 мянган төгрөгийг орон нутгийн төсвөөс, ЭМДС-аас 37,982.0 мянган төгрөгөөр санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр үндсэн дансаар улсын төсвөөс 437,391.3 мянган төгрөг, орон нутгийн төсвөөс 26,834.2 мянган төгрөг, ЭМДС-аас 22,536.9 мянган төгрөг, нэмэлт дансаар дээд шатны төсвийн захирагчаас 174,559.8 мянган төгрөг, үндсэн үйл ажиллагааны хүрээнд 1,977.2 мянган төгрөгийн санхүүжилт хүлээн авч нийт 655,301.6 мянган төгрөгийн зарцуулалт хийснээс үндсэн дансаар 478,764.6 мянган төгрөгийг зарцуулж 95.0 хувийн гүйцэтгэлтэй байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 478,764.6 мянган төгрөгийг зарцуулж 95.0 хувьтай байгаа нь цалин хөлс болон нэмэгдэл урамшуулал 9,694.0 мянган төгрөг, ажил олгогчийн НДШ 1,893.3 мянган төгрөг, байр ашиглалттай холбоотой тогтмол зардал 1,515.8 мянган төгрөг, томилолтын зардал 1,620.0 мянган төгрөг, бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж зардлыг 1,744.6 мянган төгрөг, бараа үйлчилгээний бусад зардал 7,442.6 мянган төгрөгөөр тус тус дутуу зарцуулснаас шалтгаалсан байна.

Нийт төсвийн зардлын гүйцэтгэлийг дутуу зарцуулалт нь үйл ажиллагааны урсгал зардал 24,958.7 мянган төгрөгөөр дутуу зарцуулсантай холбоотой байна.

Хүснэгт-3 Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл /мянган төгрөг/

Д/д	Хөтөлбөр, арга хэмжээний		Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлт
	Код	Нэр				
1	71602	Эмнэлгийн тусламж үйлчилгээ	699,174.64	655,301.61	43,873.04	93.7%
1.1	80101	Үндсэн үйл ажиллагааны зардал	546,427.14	512,067.77	34,359.38	93.7%
1.2	80109	ТЗШ-ийн бга-уудын тогтмол зардал	27,000.00	25,484.24	1,515.76	94.4%
1.3	80302	Нэг иргэнд ногдох нормативаар	93,547.50	85,629.60	7,917.90	91.5%
1.4	80802	Ажил олгогчоос олгох тэтгэмж,	32,200.00	32,120.00	80.00	99.8%

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

Үндсэн хөрөнгийн бүртгэлд байгаа үлдэх өртөггүй элэгдлээ бүрэн нөхсөн хөрөнгийг өмч хамгаалах зөвлөлөөр хэлэлцүүлэн шийдвэрлүүлэх.

3.8 Аудитын гол асуудал

Тайлант онд тооллогыг бүрэн явуулаагүй, харилцагч байгууллага, иргэнтэй 93.1 мянган төгрөгийн тооцоо нийлж баталгаажуулаагүй, батлагдсан орон тооноос нэг орон тоо хэтрүүлэн баталж үргүй зардал гаргасан, 2020 оны санхүүгийн тайлан сөрөг дүгнэлттэй, зөвлөмжийг бүрэн хэрэгжүүлээгүй зэрэг зөрчлүүд нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйл 16.5.3, 16.5.4, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйл 20.2.4, 20.2.5-д заасныг тус тус хэрэгжүүлж ажиллаагүй, эрх үүрэг, үнэн зөв болон тохиолдсон байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.1, 3.1.2-т хамаарах төсөвт байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит үйлдвэрийн газар нь 6 дугаар зүйлийн 6.1, 6.4-т тус тус тусгасан мэдээллийг хуульд заасан хугацаанд ил тод мэдээлэх зохицуулалттай.

Аудитаар тус хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийн давхардал, ач холбогдол, үр нөлөөг харгалзан local.audit.mn цахим бүртгэлийн хүрээнд мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулсан эсэхийг хамруулан шалгалаа.

Эрүүл мэндийн газрын 2021 онд таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын нийт 774,860.2 мянган төгрөгийн 55 мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулахаас орлогын 601,839.4 мянган төгрөгийн 33, зарлагын 87,178.9 мянган төгрөгийн 10, худалдан авалтын 67,377.9 мянган төгрөгийн 9 мэдээллийг ил тод байршуулаагүй зөрчилтэй байна.

Шийдвэрлэсэн нь: Шилэн дансны тухай хуулийг хэрэгжүүлж ажиллах албан шаардлага өгөв.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь Шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцээгүй байна гэж дүгнэлээ.

3.9.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Коронавируст халдвар тархсантай холбоотойгоор тайлант онд Эрүүл мэндийн сайд, сангийн сайдын А/337,99 67/А/268 хамтарсан тушаалаар хоёр удаагийн журам, Эрүүл мэндийн сайдын А/605 дугаар тушаалаар “Эрүүл мэндийн байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”, Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөлөөс 03, 04 дүгээр тоот тогтоолоор “Төлбөрийн хэмжээ, төлбөрийн арга, журам шинэчлэн батлах тухай”, Эрүүл мэндийн сайдын А/248, А/415 тоот тушаалаар илүү цагаар ажилласны нэмэгдэл, А/496, А/585 тоот тушаалаар мөнгөн тэтгэмж олгох, А/575, А/581 тоот тушаалаар хөрөнгө гаргах, А/788 тоот тушаалаар эрх шилжүүлэх, А/803 тоот тушаалаар нэг удаагийн мөнгөн урамшуулал олгох тус тус шийдвэрийг гаргасан байна

3.10 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Завсрын аудит хийгдээгүй болно.

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн төлбөрийн акт, албан шаардлагыг биелүүлж, 7 зөвлөмжийн хэрэгжилт 30.6 хувьтай байна.

Хүснэгт-4 Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн зөвлөмж, албан шаардлагын хэрэгжилт /мянган төгрөг/

Үзүүлэлт	Өмнөх оны илрүүлэлт		Биелэлт		Зөрүү		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Акт	4	436.3	4	436.3	0	0	0
Албан шаардлага	5	100505.6	5	100505.6	0	0	0
Зөвлөмж	7	47677.4	4	14584.7	3	33092.7	69.4
Нийт дүн	16	148618.8	13	115526.1	3	33092.7	22.3

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн НӨАТ-тай худалдан авалт хийх, харилцагч байгууллага, иргэнтэй тооцоо нийлж баталгаажуулах зөвлөмжийг давтан гаргасан тул албан шаардлага хүргүүлээ.

3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн албан шаардлага, зөвлөмжийг бүрэн хэрэгжүүлсэн эсэхийг нягтлах, биелэлтийг тооцох.

4. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 245,545.6 мянган төгрөгийн 10 алдаа зөрчил илэрснээс, 6,879.6 мянган төгрөгийн 2 алдааг залруулж, 237,395.9 мянган төгрөгийн зөрчилд 6 албан шаардлага хүргүүлж, 1,270.0 мянган төгрөгийн алдаа зөрчилд 2 зөвлөмж өглөө.

Залруулагдаагүй 8 алдаа, зөрчлийн дүн 238,665.9 мянган төгрөг нь тогтоосон ерөнхий материаллаг байдал 7,412.6 мянган төгрөгөөс хэтэрсэн тул Хязгаарлалттай дүгнэлт өглөө.

4.1 Залруулсан алдаа

Аудитаар нягтлан бодох бүртгэлийн бичилт, тооцоолол болон тайлагналын алдаатай дараах залруулгыг санхүүгийн тайланд тусгаж, баталгаажуулав. Үүнд:

- Бараа материалын журнал хөтлөлтийг 3,709.6 мянган төгрөгөөр алдаатай бүртгэсэн,
- Тайлант хугацаанд 3,170.0 мянган төгрөгийн авлагыг алдаатай бүртгэл хөтөлсөн

4.2 Албан шаардлага

1. Таван сая төгрөгөөс дээж үнийн дүн бүхий 33 удаагийн 601,839,4 мянган төгрөгийн орлого, 10 удаагийн 87,178.9 мянган төгрөгийн зарлага, 9 удаагийн 67,377.9 мянган төгрөгийн худалдан авалтын гүйлгээг мэдээлээгүй байна.

Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.4-т “таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий худалдан авсан бараа, ажил үйлчилгээний нэр, санхүүжилтийн хэмжээ, нийлүүлэгчийн нэр, хаяг”, 6.4.5-д “цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээг гүйлгээ тус бүрээр, гүйлгээний агуулга, хүлээн авагчийн нэр”, аудитаар илэрсэн алдаа, зөрчил, түүнийг арилгахаар өгсөн зөвлөмжийг бүрэн хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Шийдвэрлэсэн нь: Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.4, 6.4.5-д заасны дагуу бүрэн хэрэгжүүлж, үр дүнг тооцох, зөрчлийг давтан гаргахгүй байхад анхаарч ажиллах, Албан шаардлага өгөх.

2. Засаг даргын захирамжаар 29 орон тоотой ажиллахаар баталсан ч Эрүүл мэндийн төвийн эрхлэгч бүтэц орон тоог 30-аар баталж зарим албан хаагчдад хавсран ажилласны нэмэгдэл олгож үргүй зардал гаргасан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.3-д "Батлагдсан цалингийн сан, орон тооны хязгаарт багтаан төсвийн байгууллагын орон тоо, ажиллагчдын цалин хөлсийг тогтоох" заалтыг хэрэгжүүлж байна.

Шийдвэрлэсэн нь: Зөрчлийг таслан зогсоож, холбогдох хууль, тогтоомжийг бүрэн хэрэгжүүлэх, зөрчлийг давтан гаргахгүй байхад анхаарч ажиллах, Албан шаардлага өгөх.

3. Тайлант онд цалинг тооцон олгохдоо НДШ, ХХОАТ-ын өглөгийг шууд, НДШ-ийг цалингийн өглөг данс руу нийт 72,173,700.00 төгрөгийн журналын бүртгэл буруу хөтөлж өглөгийн дансаар дамжуулаагүй тайлагнасан байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.4-д “нягтлан бодох бүртгэл хөтлөлт нь энэ хууль болон санхүүгийн бусад хууль тогтоомжид заасан шаардлагад нийцэж байгаа эсэхийг хянах”, Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийн 5.10-т заасныг хэрэгжүүлээгүй, үнэн зөв байх батламж мэдэгдэлтэй нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Зөрчлийг таслан зогсоож холбогдох стандарт, нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичигт заасны дагуу журналыг хөтөлж зөрчлийг давтан гаргахгүй байхад анхаарч ажиллах, Албан шаардлага өгөх.

4. Эрүүл мэндийн төвийн даргын 2021 оны 12 дугаар сарын 23-ны Б/48 дугаар тушаалаар улаан бүсэд ажилласан илүү цагийн нэмэгдлийг олгохдоо улаан бүсэд ажилласныг нотлох анхан шатны баримтын бүрдэл дутуу 12,361,427.00 төгрөгийг олгож төсвийн хөрөнгийг үргүй зарцуулсан байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1-д “Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно”, 13.5-д “Анхан шатны баримтад түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн буюу шалгасан ажилтан гарын үсэг зурж, тамга, тэмдэг дарснаар уг баримт хүчин төгөлдөр болно. Цахим хэлбэрээр бүрдүүлсэн анхан шатны баримт нь цахим гарын үсгээр баталгаажсан байна”, Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д “Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах”, Засгийн газрын 2019 оны 382 дугаар тогтоолын 2 дугаар хавсралтыг хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Шийдвэрлэсэн нь: Зөрчлийг таслан зогсоож, холбогдох хууль, тогтоомжийг бүрэн хэрэгжүүлэх, зөрчлийг давтан гаргахгүй байхад анхаарч ажиллах, Албан шаардлага өгөх.

5. Жилийн эцсийн эд хөрөнгийн тооллогыг тогтоосон хугацаанд зааврын дагуу үнэн зөв, чанартай явуулж тооллогын явц үр дүнг комиссын хурлаар хэлэлцэж, тооллогын бүртгэлийг 2 хувь үйлдэж байгууллагын удирдлагад танилцуулан батлуулж, санхүүгийн албанд хүргүүлэх үүрэгтэй ч үндсэн хөрөнгийн тооллогыг 21,018.1 мянган төгрөгөөр дутуу, 131,842.7 мянган төгрөгийн бараа материалын тооллогыг бүрэн хийгээгүй байна.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 72 дугаар зүйлийн 72.4-т “эд хөрөнгийн тооллогыг тогтоосон хугацаанд үнэн зөв, чанартай явуулж дуусгах, тоолсон эд хөрөнгийн үнийг бэлтгэн нийлүүлэгчийн дагалдах баримт, тухайн үеийн зах зээлийн үнийн жишигтэй тулган шалгаж, тооллогын бүртгэлд бичих”, НББ-ийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1 дэх “Хөрөнгө, төлбөр тооцооны тооллого хийх зохион байгуулалтын асуудлыг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага, ерөнхий нягтлан бодогч нар хариуцна” гэж заасны дагуу хариуцлагагүй хандсан, тохиолдсон байх, оршин байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Зөрчлийг таслан зогсоож, холбогдох хууль, тогтоомжийг бүрэн хэрэгжүүлэх, зөрчлийг давтан гаргахгүй байхад анхаарч ажиллах, Албан шаардлага өгөх.

6. Тайлант хугацаанд иргэд, аж ахуйн нэгж байгууллагуудаас худалдан авалт хийхдээ НӨАТ-ын баримтгүй нийт 38,914,800.00 төгрөгийн худалдан авалт хийсэн, харилцагч 20 байгууллагатай тооцоо нийлж үлдэгдлийг баталгаажуулаагүй, өмнөх оны зөвлөмжийг бүрэн хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.4-т “төсвийн байгууллагын үйл ажиллагааны үр дүнг дээшлүүлэх”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5-д “дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах” заалтыг хэрэгжүүлж байна.

Шийдвэрлэсэн нь: Зөрчлийг таслан зогсоож, холбогдох хууль, тогтоомжийг бүрэн хэрэгжүүлэх, зөрчлийг давтан гаргахгүй байхад анхаарч ажиллах, Албан шаардлага өгөх.

4.3 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Бараа материалтай холбоотой асуудал

Илрүүлэлт:

Эрүүл мэндийн газраас бараа материалыг орлогод авахдаа тухай бүр орлого авдаггүй, нярвын тайлангаарх орлого, зарлагын дүн ерөнхий журналын дүнтэй орлого 49129.7 тооны 280,991.906, зарлагын дүн 36833.7 тооны 228,744.6 мянган төгрөгөөр зөрүүтэй, тооцоо нийлсэн актгүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5-д “Дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах”, Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.4-т “Дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах” гэснийг хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Өгсөн зөвлөмж:

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 16.5.4, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20.2.5-д заасныг хэрэгжүүлж ажиллах, зөрчлийг давтан гаргахгүй байх

2. Авлагатай холбоотой асуудал

Илрүүлэлт:

Тайлант хугацаанд тооцооллыг тухай бүр хийгээгүйгээс 1,270.0 мянган төгрөгийн авлагын үлдэгдэлтэй байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8-д "төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх" заалтыг хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Өгсөн зөвлөмж:

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8-д "төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх" гэснийг хэрэгжүүлж ажиллах, зөрчлийг давтан гаргахгүй байх

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2022 оны 6 дугаар сарын 10-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

№	Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Нийт алдаа, зөрчлийн дүн		Үүнээс									
				Залруулга		Акт		Албан шаардлага		Хариуцлага тооцох		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1	Сэлэнгэ сумын Эрүүл мэндийн төв	10	245,545.6	2	6,879.6	0	0	6	237,395.9	0	0	2	1,270.0